



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

“Хасбаян-Өлзийт” ХЗХ-ны хадгаламж,  
зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2, 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 9.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хасбаян-Өлзийт” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох тэмдэглэгээг 2014 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хийлгэхийг “Хасбаян-Өлзийт” ХЗХ /Б.Давхарбаяр/-нд үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000327